



ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын
газрын дарга: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@mnao.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг: oyungerels@mnao.mn

Аудитор: Ж.Ядмаа
Утас: 261740
Цахим хаяг: j_yadmaa@yahoo.com

Монгол Улсын
Үндэсний аудитын газар

Засгийн газрын IV байр
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-46
Бага тойруу-6

АГУУЛГА

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын санал дүгнэлт

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Оршил

Гадаад харилцааны сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн санхүүгийн дотоод хяналтын сул тал, үүсэх эрсдэл, хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээнд Гадаад харилцааны яамны 2013 оны үйл ажиллагаа, арга хэмжээний төлөвлөгөөнөөс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон 27 арга хэмжээний биелэлт 100 хувьтай байна.

2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудит 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин хянах
- Жилийн санхүүгийн тайлангийн уламжлалт аудит

Аудитаар хөндөгдсөн асуудлуудыг дор нэгтгэн тайлбарлав.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс байгууллагын санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Гадаад харилцааны яамны дотоод хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан түүврийн сорил гүйцэтгэж, шинжилгээ хийлээ. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Яамны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2013 онд хийх ажлын төлөвлөгөөний дагуу дараах шалгалтуудыг хийсэн байна. Тухайлбал:

- Бээжин, Сеул дэх ЭСЯ-д, Хөх хот дах ЕКГ, Эрээн дэх КГ-ын сүүлийн 3 жилийн үйл ажиллагаа,
- ГХЯ-наас 2010-2012 онд дипломат болон албан паспорт олголтын байдал,
- Өргөмжит консулын үйл ажиллагаа,
- ОХУ-ын Улаан-Үд, Эрхүү хот дахь ЕКГ-ын жилийн үйл ажиллагаанд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн байна.
- Монгол Улсаас БНХАУ-ын Хөх хот, Эрээн хотод суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын санхүүгийн үйл ажиллагаанд Гадаад харилцааны яамны Дотоод аудит, хяналт шинжилгээний газраас 2013 оны 1 дүгээр сард шалгалт хийсэн боловч тухайн хугацаанд тайланг бичиж, баталгаажуулан ирүүлээгүй байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газруудад “Инфосистемс” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Макс програмын онлайн хувилбарыг ашигладаг бөгөөд энэ нь тайлангийн чанар, уялдааг сайжруулах, хуулийн хугацаанд бэлтгэхэд үр дүнтэй байна. Мөн багцын болон ДТГ-уудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ажилдаа мөрдлөг болгон ашигласан байна.

Тайлангийн хугацаанд нэр бүхий 29 Дипломат төлөөлөгчийн газрын 2012 он, 2013 оны эхний 9 сарын санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газар, Сангийн яам, Гадаад харилцааны яам хамтран аудит хийсэн болно.

2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- ❖ Яамны харьяа ДБҮЭГ нь хөрөнгө оруулалтын харилцах данснаас 2013 оны жилийн эцэст татан төвлөрүүлсэн 47.0 саятөгрөгийн мөнгөн хөрөнгийг харилцах дансанд үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.
- ❖ Яамны харьяа ДБҮЭГ нь Төрийн өмчийн хорооны шийдвэрийн дагуу шилжиж ирсэн 30.0 сая төгрөгийн автомашиныг Засгийн газрын сангийн дансыг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.
- ❖ ДБҮЭГ нь 141.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь авлагын үлдэгдлийн 24.5 хувийг эзэлж байна.
- ❖ МОНЦАМЭ агентлаг нь хэвлэх үйлдвэрийн орцын нормыг шинэчлэн тогтоогоогүй, хэвлэл захиалга, борлуулалтад санхүүгийн бүртгэлээр тавих хяналт сул байна. Гэрэл зургийн лабораторийн үйлчилгээний үнэ тариф тодорхойгүй, орлого хүлээж авахдаа албан ёсны анхан шатны баримт үйлдэхгүй, нэгтгэн орлогын бичилт хийж байгаа нь УСНББОУС-ын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Батлагдсан орон тооны талаар:

- ГХЯ нь 2013 онд 139 орон тоотой ажиллахаас гүйцэтгэлээр 152 орон тоотой ажиллаж илүү 13 орон тоогоор хэтэрсэн байна. Дипломат төлөөлөгчийн газар нь 2013 онд 229 орон тоотой ажиллахаас гүйцэтгэлээр 235 орон тоотой ажиллаж илүү 6 орон тоогоор хэтэрсэн байна. Энэ нь МУЗГ-ын 2012 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 14 дүгээр тогтоолын 2-д заасантай нийцэхгүй байна.

Мөнгөн хөрөнгийн бүртгэлийн талаар:

- Яамны аппаратын санхүүгийн тайлангаар кассад бэлэн мөнгө 181,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д заасныг зөрчсөн байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Гадаад болон дотоод албан томилолтын талаар:

- 2013 оны гадаад болон дотоод албан томилолтын тооцоо хийсэн байдлыг шалгахад зарим албан томилолтын зарцуулалтын тайлан гаргаж өгөөгүй, баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Гадаад харилцааны яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан "Дараа тооцоо хийх журам"-тай нийцэхгүй байна.

Өр авлагын талаар:

- Дипломат төлөөлөгчийн газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 2,194.6 сая төгрөгийн өр авлагатай тайлагнасан байна. Тухайлбал: Прага, Женев, Вашингтон, Ром, Сеул, Бээжин, Брюссель, Кызыл ДТГ-уудын өр авлага нь 20.0-93.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй" байх" гэж заасныг зөрчсөн байна.
- Монгол Улсаас БНХАУ-ын Хөх хотод суугаа Ерөнхий консулын газрын 2013 оны 9 дүгээр сарын байдлаар авлагын үлдэгдэл 4,380 ам.доллар байгаагаас Гадаад харилцааны яамтай холбоотойгоор 2001-2002 онд үүссэн 4,157 ам.долларын авлага байгаа нь удаан жил тайлагнагдаж байгаа буй хоорондын тооцоог ТЕЗ-ын эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх асуудал хангалтгүй байна.

Бараа материал

- ГХЯ-ны бараа материалын үлдэгдэл (Гадаад албан паспорт) өмнөх оноос 164.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсөвт байгууллагын нөөцөд байх эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг нэмэгдүүлсэн байна.

Монгол Улсаас гадаад оронд суугаа зарим ДТГ-ын санхүүгийн аудитаар: Үндсэн хөрөнгийн талаар:

- Монгол Улсаас Кувейт Улсад суугаа элчин сайдын яам анх байгуулагдахад Кувейт Улсаас 2009 онд үйлдвэрлэгдсэн Мерседес Бенз И-230, Шевролет Тахо, Тоёото Камри маркийн нийт 3 суудлын автомашин, тавилга, тоног төхөөрөмжийг хандив тусламжаар өгснийг 2009 оноос хойш ашиглаж байгаа бөгөөд үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25.1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасны дагуу үнэлж бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна. Тус яамны үндсэн хөрөнгийн дансанд 325 нэр төрлийн 22.3 мянган ам.долларын хөрөнгө нь эргэлтийн хөрөнгө байна. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийг зохих заавар, аргачлалын дагуу ангилаагүй, хольж бүртгэсэн нь Сангийн сайдын 2005 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн орлого, зарлага, балансын дансны нэгдсэн жагсаалт батлах тухай" журмын холбогдох заалттай нийцэхгүй байна.
- Швейцарь Улсад суугаа Элчин сайдын яам нь урсгал төсвийн хөрөнгөөр BMW-1750 маркийн машин 85,885.1 ам. доллараар худалдан авчээ. Үүний урьдчилгаа төлбөрт 8,545.06 ам.доллар төлснийг үндсэн хөрөнгийн дансанд орлогоор хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд буруу илэрхийлжээ.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

- Женевт суугаа Элчин сайдын яам 71,912.1 ам.долларын лизингээр түрээслэн ашиглаж буй 3 суудлын автомашиныг оршин байгаа мэтээр санхүүгийн тайланд болон данс бүртгэлд буруу илэрхийлжээ.
- Монгол Улсаас ИБУИНВУ-д суугаа Элчин сайдын яамны 2013 оны санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн үлдэгдлийг 48.1 мянган ам.долларын зөрүүтэй илэрхийлснийг 2014 оны 1 дүгээр улиралд багтаан залруулах нь зүйтэй байна.

Визийн хуудасны тооцоо, програмын талаар:

- Монгол Улсаас Кувейт Улсад суугаа Элчин сайдын яамны 2012 он, 2013 оны эхний 9 дүгээр сарын байдлаар визийн хураамжийн үнэт цаасны тооллого хийж, хөдөлгөөний тооцоог бодоход 635 визийн хуудас бичсэнээс 2012 онд 3 хуудас, 2013 онд 6 хуудас нийт 9 ширхэг визийн хуудас дутсан байна. Монгол Улсаас БНХАУ-ын Эрээн хотод суугаа Консулын газар 2013 оны 3 дугаар сараас 10 дугаар сарын хооронд өдөрт 200-400 гаруй иргэнд визийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд хүний нөөцийн хүрэлцээгүй, визийн онлайн програм тасалдаж саатах зэргээс шалтгаалан ачаалал ихэдсэнээс 2012 онд MS Excel програмаар гаргасан визийн стикер нэр, үнийн дүнгүй бичигдэх, орлогын дүн зөрүүтэй хэвлэгдэх зэрэг зөрчил үүссэн байна.

Бараа материалын талаар:

- Монгол Улсаас Сингапур Улсад суугаа Элчин сайдын яам нь 2013 оны 9 сарын байдлаар 1.8 мянган ам.долларын бараа материал худалдан авч, материалын орлого, зарлагын тайлан гаргалгүй, мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардалд бичиж тайлагнасан байна.
- Монгол Улсаас ИБУИНВУ-д суугаа Элчин сайдын яамны 2013 оны санхүүгийн байдлын тайланд бараа материалын үлдэгдлийг 27.2 мянган ам.доллараар зөрүүтэй илэрхийлснийг 2014 оны 1 дүгээр улиралд багтаан залруулах шаардлагатай байна.

Үндсэн болон үндсэн бус орлогын талаар:

- Монгол Улсаас Сингапур Улсад суугаа Элчин сайдын яам нь 2013 оны эхний 9 сарын байдлаар өөрийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаанаас 37.5 мянган ам.долларын орлогын төлөвлөгөөтэйгээс 58.6 мянган ам.долларын орлого олсон байна. Үүнээс 12.7 мянган ам.долларын орлогыг тайлан бүртгэлд тусгалгүйгээр шагнал урамшуулалд зарцуулж, үлдсэн 45.9 мянган ам.долларын орлогыг тайлан бүртгэлд тусгасан хэдий ч улсын төсөвт төвлөрүүлэлгүй үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна:

- Монгол Улсаас Сингапур Улсад суугаа Элчин сайдын яам нь 2012 онд урсгал үйл ажиллагааны төсвийг 233.6 мянган ам.доллараар хэтрүүлжээ. 2013 оны эхний 9 сарын байдлаар тээвэр шатахуун 3.8 мянга, гэрэл цахилгаан 8.7 мянга, шуудан холбоо 2.4 мянга, бичиг хэрэг 5.2 мянга, гадаад зочны зардал 3.9 мянга, сургалт семинар 10.6 мянга, гадаад томилолтын зардал 15.9 мянга ам.доллараар тус тус хэтэрсэн байна. Хэтэрсэн шалтгааныг авч үзвэл 2013 онд Эдийн засгийн форм,

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Азийн оюутан залуучуудын универиад наадам зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулсан холбоотойгоор төсөв төлөвлөгөөндөө тусгагдаагүй зардал гарсан байна.

- Дипломат төлөөлөгчийн газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан балансаар батлагдсан төсвөө Женев дэх Элчин сайдын яам 77.1 сая, Гавана дахь Элчин сайдын яам 13.7 сая, Вашингтон дахь Элчин сайдын яам 53.3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлэн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасныг зөрчсөн байна.

Нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын талаар:

- ДТГ-ын санхүүгийн ажилтнуудад зориулсан онлайн сургалтыг хагас, бүтэн жилээр зохион байгуулж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Эдгээр асуудал нь дээр дурдсан санхүүгийн дотоод хяналтын талаархи санал бодол, менежментийн захидлын хамт илрүүлсэн гол зүйлсийг бүрдүүлж байгаа болно.

Тус ТЕЗ-ийн харьяа төсвийн шууд захирагч 3, төвлөрүүлэн захирагч 1, Засгийн газрын тусгай сан 1 зэрэг байгууллагад хийгдсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг нэгтгэн харуулж байна. Үүнд:

Гадаад харилцааны яамны аппарат:

Яамны аппаратын кассын гүйлгээг яамны харьяа Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газрын аж ахуйн нярав давхар эрхлэн гүйцэтгэж байгаа бөгөөд 2013 оны жилийн эцсийн бэлэн мөнгөний тооллогыг хийж, тооцоог бодохдоо байгууллага бүрээр үлдэгдлийг ангилан харуулаагүй байгааг залруулах талаар зөвлөж, “**Зөрчилгүй**” санал дүгнэлт өгсөн.

Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан:

Яамны харьяа Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн 2013 оны жилийн эцсийн тайлангаар 34,8 сая төгрөгийг сангаас зориулалт бусаар олгосон зөрчлийг илрүүлэн Сангийн тайлагнал, зарцуулалтад зөвлөмж өгч, “**Хязгаарлалтай**” санал дүгнэлт гаргасан.

Дипломат төлөөлөгчийн газар:

Дипломат төлөөлөгчийн газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар Монгол Улсаас гадаад оронд суугаа зарим ДТГ-ын нэгтгэл хийсэн санхүүгийн аудитаар 109.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн 1 актыг тогтоож, нийт 5.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 4 албан шаардлага бичиж, аудитын хугацаанд улсын төсөвт 689.4 сая төгрөгийг төвлөрүүлээ.

ДТГ-ын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “**Зөрчилгүй**” санал дүгнэлт өгсөн.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар:

ҮАГ-ын захиалгаар “Ди Эй Би Жи Аудит” ХХК нь тус газрын 2013 оны санхүүгийн тайланд аудит хийж, “Зөрчилгүй” саналдүгнэлт өгсөн байна.

МОНЦАМЭ агентлаг:

ҮАГ-ын захиалгаар “Нийслэл аудит” ХХК тус байгууллагын 2013 оны санхүүгийн тайландаудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний аудитын газраас Гадаад харилцааны сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 5 зөвлөмж өгсөн бөгөөд 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэх шатанд байна. Тухайлбал: Хэлэлцээний үр дүнд ОХУ-д суугаа ЭСЯ-ны 2 дугаар байрны засварын үнэ, түрээсийн хугацаа зэрэг олон асуудлыг тохирсон байна. Гэвч “Центр Регион Эстейт” ХХК-иас 2014 оны 2 дугаар сард гэрээний төслөө ирүүлэхдээ өмнө нь тохиролцсон зарим зүйлээсээ буцаж, өөр заалт тусгасан байна. Иймд гэрээний төсөлд ажлын хэсгийн гишүүдээс санал авч хариу төсөл боловсруулж хянах түвшинд байна.

Аудитын санал дүгнэлт

Бид Гадаад харилцааны сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.

Үндэсний аудитын газар

2014 оны 4 дүгээр сар

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

210546 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV Байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 695

танай _____-ны № _____-Т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Гадаад харилцааны яамны удирдлага Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Зөрчилгүй санал дүгнэлт

Гадаад харилцааны сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, аргачлалын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1 Батлагдсан орон тоо

Асуудал 2 Мөнгөн хөрөнгийн бүртгэл

Асуудал 3 Гадаад болон дотоод томилолт

Асуудал 4 Авлагын бүртгэл

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Гадаад харилцааны яамны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Гадаад харилцааны яамны хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Гадаад харилцааны яамны удирдлага болон санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Асуудал 1: Батлагдсан орон тоо

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

ГХЯ нь 2013 онд 139 орон тоотой ажиллахаас гүйцэтгэлээр 152 орон тоотой ажиллаж 13 орон тоогоор хэтэрсэн байна.

Дипломат төлөөлөгчийн газар нь 2013 онд 229 орон тоотой ажиллахаас гүйцэтгэлээр 235 орон тоотой ажиллаж 6 орон тоогоор хэтэрсэн байна. Энэ нь МУЗГ-ын 2012 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 14 дүгээр тогтоолын 2-д заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

МУЗГ-ын 2012 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 14 дүгээр тогтоол, Төсвийн тухай хуулийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг тус тус мөрдөж ажиллах,

Эрсдэлүүд

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг үйлчлүүлэгчид танилцуулан зөвшөөрүүлж, гарын үсэг зуруулсан болно.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Асуудал 2: Мөнгөн хөрөнгийн бүртгэл

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Яамны аппаратын санхүүгийн тайлангаар кассад бэлэн мөнгө 181,495.5 сая төгрөгийн үлдэгдэл байна. Энэ нь Сангийн Сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн Сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах,

Эрсдэлүүд

Кассын үлдэгдэл ашиглагдах, алдагдах;
Кассын няравгүйгээс тайлан тооцоо буруу гарах, дутагдал шамшигдал гарах,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг үйлчлүүлэгчид танилцуулан зөвшөөрүүлж, гарын үсэг зуруулсан болно.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Асуудал 3: Гадаад болон дотоод томилол

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

2013 оны гадаад болон дотоод томилолтын тооцоо хийсэн байдлыг шалгахад зарим томилолтын зарцуулалтын тайлан гаргуулаагүй, баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Гадаад харилцааны яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан “Дараа тооцоо хийх журам”-тай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2011 оны 132 болон 188 дугаар тушаалаар батлагдсан тарифыг мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Томилолтын тооцоо буруу хийгдэх,
Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг
үйлчлүүлэгчид танилцуулан
зөвшөөрүүлж, гарын үсэг
зуруулсан болно.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Асуудал 4: Авлага, өглөгийн бүртгэл

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Дипломат төлөөлөгчийн газрын 2013 оны санхүүгийн тайлан балансаар 2,194.6 сая төгрөгийн өр авлагатай тайлагнасан байна. Тухайлбал: Прага, Женев, Сеул, Бээжин, Брюсель, Кызыл ДТГ-уудын өр авлага нь 20.0-93.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Хөх хотод суугаа Ерөнхий консулын газрын 2013 оны 9 дүгээр сарын байдлаар авлагын үлдэгдэл нь 4,380 ам.доллар байгаагаас Гадаад харилцааны яамтай холбоотойгоор 2001-2002 онд үүссэн 4,157 ам.долларын авлагатай байгааг ТЕЗ – ын эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй байна.

Эрсдэлүүд

Авлага, өр төлбөр үндэслэлгүйгээр нэмэгдэх, төлөгдөх найдваргүй болох;

Авлага, өглөг үүссэн тухай бүр бүртгэлд тусгаагүйгээс илүү, дутуу илэрхийлэгдэх.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг мөрдөж ажиллах.

ДТГ газар бүрээр улирал, жил тутамд авлага, өглөгийн тооцоо нийлж актаар баталгаажуулж байх.

Удаан жил дамжсан хоорондын тооцоог ТЕЗ-ын эрх хэмжээнд шийдвэрлэх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг үйлчлүүлэгчид танилцуулан зөвшөөрүүлж, гарын үсэг зуруулсан болно.

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН АУДИТ
ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

ҮЗҮҮЛЭЛТ	төгрөгөөр	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,945,244,516.46	4,601,140,205.89
Кассанд байгаа бэлэн мөнгө	1,543,837,070.78	1,105,545,330.51
Төгрөг\ ЖМС	73,534,767.46	195,646,388.56
Гадаад валют	1,470,302,303.32	909,898,941.95
Банкинд байгаа бэлэн мөнгө	2,401,407,445.68	3,495,594,875.38
Төгрөг	117,139,400.00	69,793,657.74
Улсын төсвийн харилцах	28,170,900.00	0.00
Төсөвт байгууллагын харилцах	88,968,500.00	0.00
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	69,793,657.74
Гадаад валют	2,284,268,045.68	3,425,801,217.64
Улсын төсвийн харилцах	2,284,268,045.68	3,425,801,217.64
АВЛАГА	2,685,617,677.30	3,491,078,546.52
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	92,420,133.29
Төлбөртэй үйлчилгээний авлага	443,787,759.63	432,561,038.38
Бусад авлага	2,241,829,917.67	2,966,097,374.85
Байгууллагаас авах авлага	2,060,472,257.08	2,809,963,612.01
Бусад зардлын тооцооны авлага	2,060,472,257.08	2,809,963,612.01
Хувь хүмүүсээс авах авлага	181,357,660.59	156,133,762.84
УРЬДЧИЛГАА	1,260,250,000.00	6,650,000.00
Бусад урьдчилгаа	1,260,250,000.00	6,650,000.00
Урьдчилгаа тооцоо	1,253,600,000.00	0.00
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	1,253,600,000.00	0.00
Урьдчилж гарсан зардал	6,650,000.00	6,650,000.00
Урьдчилж төлсөн зардал	6,650,000.00	6,650,000.00
БАРАА МАТЕРИАЛ	3,035,990,323.29	2,602,126,611.98
Түүхий эд материал	1,158,043,436.31	993,703,974.49
Тусгай зориулалттай материал	1,158,043,436.31	993,703,974.49
Хангамжийн материал	1,833,351,592.98	1,573,780,285.99
Бичиг хэргийн материал	9,680,101.58	37,935,306.56
Аж ахуйн материал	429,692,622.00	489,561,642.51
Сэлбэг хэрэгсэл	949,500.00	902,500.00
Түлш, шатах тослох материал	35,307,143.93	7,100,981.86
Барилгын засварын материал	30,030,262.51	17,081,234.74
Хүнсний материал	34,872,979.80	13,804,932.17
Баглаа боодол	440,605.07	440,605.07
Бусад бараа материал	1,292,378,378.09	1,006,953,083.08
Мал амьтад	8,150,000.00	0.00
Бусад	36,445,294.00	34,642,351.50
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,927,102,517.05	10,700,995,364.39
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	72,628,960,965.45	83,873,495,723.36
Газар	163,350,127.68	194,708,283.07
Биет хөрөнгө	72,373,612,900.33	83,597,642,285.68
Барилга, байгууламж, орон сууц	58,955,948,970.80	67,350,483,508.21
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	106,900,868,470.96	124,405,322,103.43

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(47,944,919,500.16)	(57,054,838,595.22)
Авто-тээврийн хэрэгсэл	3,805,471,673.91	6,302,486,428.20
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	7,388,285,304.97	11,040,554,402.26
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(3,582,813,631.06)	(4,738,067,974.06)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,621,791,773.06	2,852,769,630.49
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	5,072,236,231.83	6,212,636,451.58
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(2,450,444,458.77)	(3,359,866,821.09)
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,233,863,436.37	2,976,286,810.01
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	4,404,850,297.39	5,696,203,666.71
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(2,170,986,861.02)	(2,719,916,856.70)
Зам, гүүрийн байгууламж	115,074,148.03	58,790,837.43
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	461,082,045.02	461,082,045.02
Зам, гүүрийн байгууламж - Хуримтлагдсан элэгдэл	(346,007,896.99)	(402,291,207.59)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,797,135.00	3,797,135.00
Бусад үндсэн хөрөнгө	140,498,760.12	159,344,263.15
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	234,569,628.44	333,590,265.70
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(104,188,542.32)	(184,408,676.55)
Номын фонд	10,117,674.00	10,162,674.00
Дуусаагүй барилга, байгууламж	4,497,167,003.04	3,893,683,673.19
Биет бус хөрөнгө	91,997,937.44	81,145,154.61
Програм хангамж	90,782,494.93	80,368,417.56
Програм хангамж - Анхны өртөг	114,462,392.09	118,634,407.89
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(23,679,897.16)	(38,265,990.33)
Бусад биет бус хөрөнгө	1,215,442.51	776,737.05
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	3,606,862.92	4,399,284.60
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(2,391,420.41)	(3,622,547.55)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	83,556,063,482.50	94,574,491,087.75
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,928,062,132.88	1,436,217,280.36
Өглөг	1,924,762,855.88	1,432,579,317.97
Ажилчидтай холбогдсон тооцоо	45,838,600.00	0.00
ХАОАТ-ын өглөг	45,838,600.00	0.00
Бусад өглөг	1,878,924,255.88	1,432,579,317.97
Байгууллагад төлөх өглөг	1,785,255,196.12	1,317,384,559.62
Хувь хүмүүст төлөх өглөг	93,669,059.76	115,194,758.35
Урьдчилж орсон орлого	3,299,277.00	3,637,962.39
Төсөвт байгууллага	0.00	3,637,962.39
Урьдчилж орсон орлого	0.00	3,637,962.39
Бусад урьдчилж орсон орлого	3,299,277.00	0.00
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,928,062,132.88	1,436,217,280.36
Засгийн газрын хувь оролцоо	81,628,001,349.62	93,138,273,807.39
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	78,653,535,585.68	78,653,535,585.68
Хуримтлагдсан үр дүн	(17,774,828,481.91)	(11,396,384,126.03)
Өмнөх үеийн үр дүн	(17,774,828,481.91)	(17,867,470,772.65)
Тайлант үеийн үр дүн	0.00	6,471,086,646.62
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,169,812,648.92	5,169,808,153.72
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	15,579,481,596.93	20,711,314,194.02
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	81,628,001,349.62	93,138,273,807.39
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	83,556,063,482.50	94,574,491,087.75

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН АУДИТ
ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

ҮЗҮҮЛЭЛТ	төгрөгөөр	
	Өмнөх он	Тайлант он
ТАТВАРЫН ОРЛОГО	1,014,310,097.15	181,302,687.70
Бараа, үйлчилгээний албан татвар	1,014,310,097.15	181,302,687.70
Зарим төрлийн барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн татвар	1,014,310,097.15	181,302,687.70
Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар	1,014,310,097.15	181,302,687.70
Улсын тэмдэгтийн хураамж	1,014,310,097.15	181,302,687.70
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,142,264,405.02	52,597,344,994.36
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	38,142,264,405.02	52,597,344,994.36
Улсын төвлөрсөн төсвөөс	37,291,900,597.44	52,569,528,383.12
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	31,624,295,731.35	39,800,307,092.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	383,513,084.77	468,345,874.00
Хөрөнгийн	5,076,094,822.60	11,759,340,317.12
Сангийн сайдын багцаас санхүүжүүлсэн	207,996,958.72	41,535,100.00
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт	0.00	500,000,000.00
Төсөвт байгууллагаас	670,000,000.00	0.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	670,000,000.00	0.00
Нийгмийн даатгалын сангаас	7,163,807.58	27,816,611.24
НДС-ийн шилжүүлэг	7,163,807.58	27,816,611.24
Бусад Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	173,200,000.00	0.00
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	173,200,000.00	0.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,491,168,177.33	22,936,987,480.87
Өмчийн орлого	41,176,260.42	24,491,637.80
Хүүгийн орлого	104,580.42	0.00
Түрээсийн орлого	41,071,680.00	24,491,637.80
Төрийн өмч түрээслүүлсний орлого	41,071,680.00	24,491,637.80
Бараа, үйлчилгээний борлуулалт	22,449,991,916.91	22,912,495,843.07
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	22,449,991,916.91	22,912,495,843.07
Үндсэн үйл ажиллагааны орлого	18,366,593,135.93	18,366,526,709.28
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	4,083,398,780.98	4,272,205,433.37
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	273,763,700.42
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	61,647,742,679.50	75,715,635,162.93
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	15,697,697,987.12	18,107,684,793.96
Үндсэн болон нэмэгдэл цалин	14,891,314,704.70	17,181,429,574.33
Үндсэн цалин	14,891,314,704.70	17,181,429,574.33
Нийгмийн хамгааллын шимтгэл	806,383,282.42	926,255,219.63
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	806,383,282.42	926,255,219.63
Тэтгэврийн даатгалын шимтгэл	806,383,282.42	926,255,219.63
УРСГАЛ ЗАРДАЛ	17,370,119,503.39	20,736,546,703.12
